

HISTORY OF MONGOLS IN PHOTOGRAPHS VOL. III

МОНГОЛ ОРОН
МОНГОЛЧУУД

МОНГОЛ ИЯИ
МОНГОЛЫ

III





РОССИЙСКАЯ АКАДЕМИЯ НАУК
ИНСТИТУТ ИСТОРИИ МАТЕРИАЛЬНОЙ КУЛЬТУРЫ



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ ОРОН МОНГОЛЧУУД

ЭМХЭТГЭСЭН: С.ЧУЛУУН, М.В.МЕДВЕДЕВА



(Г.И.Боровкагийн Монголд ажилласан судалгааны
эрэл зургийн цуглувлаас)

МОНГОЛИЯ И МОНГОЛЫ

СОСТАВИТЕЛИ: МЕДВЕДЕВА М.В., ЧУЛУУН С.

Улаанбаатар-Санкт-Петербург
2017





Улаанбаатар, Судар бичгийн хүрээлэнгийн
хашаан доторх байшин, өмнө тал

Улан-Батор. Дом во дворе Ученого Комитета,
южный фасад.

ДАА-900
ННА-63
Ч-891

HISTORY OF MONGOLS IN PHOTOGRAPHS VOL. III

ОХУ-ын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэн болон Монгол Улсын ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн зөвшөөрлөөр хэвлэн нийтлүүлэв.

Книга издается по решению Ученого Совета Института истории материальной культуры РАН и Ученого Совета Института истории и археологии МАН.

Уг бүтээл нь Оросын Холбооны Улсын Санкт-Петербург хот дахь Оросын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн гэрэл зургийн сан хэмрэгээс 1925-1926 онуудад Монгол улсад ажилласан судлаач Г.И.Боровкагийн гэрэл зургийн цуглуулгаас нийтлүүлж байна. Эдгээр гэрэл зургууд нь урьд өмнө хэвлэгдээгүй бөгөөд эдүгээ анх удаагаа орос, монгол хэлээр нийтлэгдэж байгаа болно.

1920-иод оны үеийн Монголчуудын амьдрал, монголын байгал, хүмүүсийн намтар түүхтэй холбоотой гэрэл зургуудаас гадна археологийн судалгааны ажил, түүний үр дүнгийн тухай голдуу байна.

Монголын түүх, угсаатны зүй, орчин үеийн түүх, археологийн талаар тусгайлан судалгаа хийж буй оюутан, магистр, докторант, судлаачид хэн бүхэнд зориулагдсан болно.

Данный труд представляет уникальные фотографии из фондов Института истории материальной культуры РАН, сделанные советским археологом Г.И.Боровкой во время его работы в Монголии в 1925-1926 гг. Фотоснимки ранее не публиковались и впервые издаются на русском и монгольском языках.

Помимо фотографий монгольской природы, жизни и быта монголов двадцатых годов прошлого столетия, значительное место занимают фотоснимки, запечатлевшие археологические раскопки и их результаты.

Книга рассчитана на широкий круг читателей, интересующихся Монголией, и студентов, магистрантов, докторантов и исследователей, занимающихся ее современной историей, этнографией и археологией.

Эмхтгэсэн: С.Чулуун., М.Медведева
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Б.Баясгалан
Уран сайхны редактор: С.Цогтбаяр
Зургийн хуулбар: Н.А.Лазаревская
Техник редактор: Г.Хавчур
Хэвлэлийн хуудас: 34 х.х
Хэвлэлийн газар: Admon printing
Хэвлэсэн тоо: 300 ширхэг

Составители: Медведева М.В., Чулуун С.
Компьютерная верстка: Баясгалан Б.
Художественный редактор: Цогтбаяр С.
Сканирование изображений: Лазаревская Н.А.
Технический редактор: Хавчур Г.
Печатный лист: 34
Издательство: Адмонпринтинг
Тираж: 300 экз.

Энэхүү ном нь зохиогчийн эрхийн хуулиар хамгаалагдсан бөгөөд зөвшөөрөлгүйгээр хувилан олшууллах, олон нийтийн зорилгоор хэрэглэх, радио, зурагт, сонин хэвлэлд нийтлүүлэх ээрэг бусад бүх төрлийн хууль бус аль ч хэлбэрээр ашиглахыг хатуу хориглоно.

Авторское право на эту книгу защищается на законной основе и никакая часть данной публикации не может быть воспроизведена или передана в любой форме или любыми средствами, включая фотокопирование, запись, или другие электронные или механические методы без разрешения.

ISBN 978-99978-854-5-6

© С.Чулуун, М.В.Медведева
© ИИМК РАН
© Институт истории и археологии МАН

ISBN 978-99978-854-5-6



9 789997 885456

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ

- Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгч Д.Рэгдэл 6
- Оросын Шинжлэх ухааны Академийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн захирал В.А.Лапшин 8

УДИРТГАЛ

- С.Чулуун, М.В.Медведева
1920-иод оны Монгол орон ба Монголчуудын ертөнц 12

ГЭРЭЛ ЗУРГИЙН ЦУГЛУУЛГА 24-237

ОРОС, МОНГОЛЫН АРХИВЫН ЗАРИМ БАРИМТААС 238

ГЭРЭЛ ЗУРГИЙН ЦЭС 246

ОГЛАВЛЕНИЕ

ПРЕДИСЛОВИЕ

- Президент МАН, академик Д.Рэгдэл 7
- Директор ИИМК РАН В.А.Лапшин 8

ВВЕДЕНИЕ

- М.В.Медведева, С.Чулуун
Монголия и мир Монголов 1920-х годов 18

КОЛЛЕКЦИИ ФОТОГРАФИЙ 24-237

**НЕКОТОРЫЕ ДОКУМЕНТЫ ИЗ РОССИЙСКИХ И
МОНГОЛЬСКИХ АРХИВОВ 238**

КАТАЛОГ ФОТОГРАФИЙ 246



ӨМНӨХ ҮГ

ХХ зууны эхэн үеийн Монгол орон ба монголчуудын тухай нэгэн сонирхолтой ном Та бүхний гар дээр очиж байна. 1925 онд Оросын археологич, скиф судлаач Г.И.Боровко залуухан судлаач байхдаа Монголд явуулсан археологийн судалгааны үедээ авсан гэрэл зургийн бүрэн цуглувлагыг ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн захирал С.Чулуун, Оросын ШУА-ийн Эдийн Соёлын түүхийн хүрээлэнгийн гэрэл зургийн архивын эрхлэгч М.В.Медведева нар эмхэтгэн ийнхүү нийтийн хүртээл болгож байгаа юм.

Номонд орсон гэрэл зургуудыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газраас Олон Улсын Монгол Судлалын Холбоотой хамтран хэрэгжүүлсэн “Дэлхийд тархсан монгол өв” төслийн хүрээнд шинжлэх ухааны доктор, профессор С.Чулуун Оросын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнд томилолтоор ажиллаж байхдаа уг хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид, удирдлагын дэмжлэгээр үзэж судлан хамтран ном бүтээл болгон хэвлүүлэхээр анх тохиролцжээ. Улмаар Оросын талын эрдэмтдийн дэмжлэгээр эдгээр гэрэл зургуудыг тусгай каталоги болгон нийтлүүлэх гэрээг байгуулжээ. Харин хэвлэн нийтлүүлэхэд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яамнаас дэмжлэг үзүүлж олон түмэнд хүргэж байгаа болно.

Г.И.Боровка бол 1924 анх Хүннүгийн язгууртны цогцолбор дурсгал бүхий Ноён ууланд ажиллахаар ирж, 1925 онд Туул голын сав нутагт, 1926 онд Ноён ууланд археологийн малтлага тус тус явуулсан судлаач юм. Түүний судалгааг нэг талаас Монголын орчин үеийн шинжлэх ухааны анхны байгууллага Судар бичгийн хүрээлэн дэмжих байсан юм. Ялангуяа 1925 оны Туул голын сав нутаг дахь хээрийн судалгаа бол Судар бичгийн хүрээлэнгээс тусгайлан захиалж, Монгол улсад археологийн судалгааг мэргэжлийн түвшинд явуулах, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор хийгдсэн ажил болно.

Энэхүү бүтээлд Монгол улсын Шинжлэх ухааны байгууллагын түүхтэй холбоотой маш олон гэрэл зураг байгаад бид нэн талархаж байгаа бөгөөд манай оронд орчин цагийн шинжлэх ухаан нэвтрэн хөгжих түүхийн эхний үеийг дэлгэрүүлэн судлахад ихээхэн чухал хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй юм. Судар бичгийн хүрээлэнгийн анхны дарга Онходын Жамъян нарын гэрэл зураг, судар бичгийн хүрээлэнгийн анхны байр, түүний орчин тойрны байдал зэрэг олон түүхэн гэрэл зургуудыг уншигч Та анх удаагаа эндээс үзэх болно. Мөн 1920-иод оны монголчуудын ахуй амьдрал, байгаль орчин, сүм хийдийн талаар ч өргөн хүрээний мэдээлэл олж авах, тодруулан судлах боломж бүрдэж байгаа юм.

Энэ төрлийн гэрэл зургийн цомгуудыг үргэлжлэн хэвлэх төлөвлөгөөтэй бөгөөд Монгол улсын Шинжлэх ухааны Академийн зүгээс Монголын тухай хуучин гэрэл зургуудыг цомог хэлбэрийн цувралаар эмхэтгэн нийтлүүлэх ажлыг байнга дэмжин ажиллах болно. Энэ эрэл хайгуул, судалгааны явцад тусгайлсан мэдээлэлийн сан бий болгох ажлыг Түүх, Археологийн хүрээлэнд эхлүүлээд байгааг энэ ялдамд уншигч Танд дуулгахад таатай байна.

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ,
АКАДЕМИЧ Д.РЭГДЭЛ



ПРЕДИСЛОВИЕ

Вниманию читателей предлагается интересное издание о Монголии и монголах начала XX века. Совместными усилиями директора Института истории и археологии Монгольской Академии наук С.Чулууна и заведующей Научным архивом Института истории материальной культуры РАН М.В.Медведевой выходит в свет полная коллекция снимков, сделанных в 1925 г. во время археологических исследований, проведенных в Монголии, тогда еще молодым российским археологом и исследователем скифов Г.И.Боровкой.

В рамках проекта "Наследие монголов, распространенное по миру", претворенного Президиумом Академии наук Монголии совместно с Международной ассоциацией монголоведения, доктор исторических наук, профессор С.Чулуун, ознакомившись с данными снимками, будучи в командировке в Институте истории материальной культуры РАН, договорился с руководством Института об их издании. При непосредственной поддержке учёных с российской стороны был заключён договор о публикации этих снимков в форме каталога, а издание каталога осуществлено при финансовой поддержке Министерства образования, культуры, науки и спорта Монголии.

Г.И.Боровка впервые прибыл в Монголию в 1924 г. для проведения раскопок в Ноин-Уле, где находятся захоронения хуннской знати. В 1925 г. он провел археологические изыскания в бассейне реки Толы, а в следующем 1926 г. он еще раз принял участие в раскопках Ноин-Улы. В его исследованиях было особенно заинтересовано первое современное научное учреждение Монголии – Ученый Комитет. В частности, раскопки в бассейне реки Тола были проведены по специальному заказу Ученого Комитета с целью проведения в Монголии археологических изысканий и охраны исторического и культурного наследия на профессиональном уровне.

Мы рады, что коллекция включает в себя значительное количество снимков, связанных с историей научного учреждения Монголии, и они, несомненно, послужат важным источником в изучении истории становления и распространения современной науки в Монголии, особенно на начальной ее стадии. Взору читателей впервые представлены снимки первого Председателя Ученого Комитета - Онхот Жамъяна, первое здание Ученого Комитета, его панорама и многое другое. Снимки дают не только наглядное представление о послереволюционном быте и укладе жизни монголов, об окружающей их среде, а также о буддийских монастырях и храмах по состоянию на 1925 г., но и включают в себя широкий спектр ценной информации для дальнейшего их изучения.

Мы планируем продолжать издание подобных фотоальбомов. В свою очередь, Монгольская Академия наук и впредь будет поддерживать работу по серийной публикации старых снимков о Монголии в виде альбомов. Пользуясь случаем, хотелось бы отметить, что в ходе поисков и исследований фотодокументов в Институте истории и археологии Академии наук Монголии был учрежден Фонд исторических документов.

ПРЕЗИДЕНТ АКАДЕМИИ НАУК МОНГОЛИИ,
АКАДЕМИК Д.РЭГДЭЛ



ӨМНӨХ ҮГ

Энэхүү бүтээл нь Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, археологийн хүрээлэн ба Оросын Шинжлэх Ухааны Академийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн хооронд 2016 онд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн анхны хамтарсан төсөл юм.

Оросын ШУА-ийн Эдийн соёлын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний архивт XIX-XX зууны үеийн Орос болон хөрш оруудын археологи, угсаатны зүй, уран барилгын түүх хийгээд дурсгалт зүйлүүдийн хадгалалт, хамгаалалтад холбогдох гар бичмэл ба гэрэл зургийн арвин баялаг цуглуулга хадгалагдаж байна. Тэдгээрийн тооңд 1859 онд байгуулагдсан Оросын Эзэн хааны археологийн комисс, түүний суурин дээр 1919 онд байгуулагдсан Эдийн соёлын түүхийн Улсын Академи болон түүнийг залгамжилсан Оросын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн сан хөмрөгүүд багтана.

Оросын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл нь архивын баримт материалыг хэвлэн нийтлүүлэх замаар археологийн судалгааны үзэл санаа, түүхийг сурталчлах явдал билээ. Тиймээс Монголын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн захирал, доктор С.Чулуун надад хандан Эдийн соёлын түүхийн Улсын Академийн эрдэм шинжилгээний ажилтан Г.И.Боровкагийн 1925 онд Монголд явуулсан хээрийн судалгааны үед авсан гэрэл зургийн цуглуулгыг хэвлүүлэх санал тавьсныг дуртайяа хүлээн авсан билээ.

Монголын археологи, угсаатны зүйн шинжилгээ судалгааны тухай нэн ховор эх хэрэглэгдэхүүн болох энэхүү цуглуулгыг бид хамтран хэвлүүлж, уг бүтээлээрээ улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөж, амь наасаа харамсалтайгаар алдсан нэрт археологич, мэргэжил нэгт нөхөр Григорий Иосифович Боровкагийн (1894-1942) гэгээн дурсгалыг хүндэтгэж байна. Үүний хамт 1937 онд Г.И.Боровкаг шоронд хоригдож байсан үед иргэний зориг гарган, түүний гэрэл зургийн цуглуулгын боловсруултыг хийсэн манай архивын ажилтан К.Назароваг нэхэн дурсах ёстой.

Эцэст, бид энэхүү бүтээлээ 2019 оны 4 сарын 18-нд тохиох Эдийн соёлын Академи байгуулагдсаны 100 жилийн ойд зориулан өргөн барьж байна.

ОРОСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ЭДИЙН СОЁЛЫН ТҮҮХИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
В.А. ЛАПШИН

ПРЕДИСЛОВИЕ

Настоящее издание является первым совместным проектом Института истории и археологии Монгольской академии наук и Института истории материальной культуры Российской академии наук в рамках договора о сотрудничестве между двумя институтами, подписанного в 2016 году.

Научный архив Института истории материальной культуры РАН содержит богатейшую коллекцию рукописных и фотодокументов по археологии, этнографии, истории архитектуры и охране памятников России и сопредельных стран и территорий XIX–XX веков. В их числе фонды Императорской археологической комиссии (ИАК, 1859) и Государственной Академии истории материальной культуры (ГАИМК, 1919), преемником и наследником которых является Институт истории материальной культуры РАН (ИИМК РАН).

Одной из уставных форм деятельности ИИМК РАН является пропаганда истории археологии и археологической мысли путем издания архивных материалов. Вот почему я с радостью отклинулся на предложение директора Института истории и археологии МАН С. Чулууна издать коллекцию фотографий, сделанных сотрудником ГАИМК Г.И.Боровкой в 1925 году во время экспедиции в Монголию.

Эта коллекция содержит уникальный материал, как по археологии, так и этнографии Монголии. Одновременно данное издание является данью памяти замечательного археолога, нашего коллеги Григория Иосифовича Боровки (1894-1942), трагически погибшего в эпоху террора. Необходимо вспомнить и сотрудницу архива ГАИМК К.Назарову, которая обработала эту коллекцию фотографий в 1937 году, когда Г.И.Боровка находился в тюремном заключении, что являлось в то время актом гражданского мужества.

Наконец, мы посвящаем данное издание грядущему столетнему юбилею Государственной Академии истории материальной культуры, который состоится 18 апреля 2019 года.


ДИРЕКТОР ИНСТИТУТА ИСТОРИИ МАТЕРИАЛЬНОЙ
КУЛЬТУРЫ РОССИЙСКОЙ АКАДЕМИИ НАУК
В.А. ЛАПШИН



Григорий Иосифович БОРОВКА
(Потсдам. 1929 он)

Григорий Иосифович БОРОВКА
(Потсдам. 1929 г.)

Схематическая археологическая



▲ Населенные пункты, строения.

— Дороги.

—~— Ручьи.

—~— Полувасохшие ручьи.

—~— Путь следования экспедиции.

— Песчаные выдувы с остатками древности.


— Выдувы, на которых были обнаружены следы неолита.

10 5 0

Сторона квадрата

Цифры при упоминании о монументах
указывают количество могил

карта среднего течения р. Толы.



- Прямоугольные плиточные погребения.
- Плиточные погребения с вогнутыми сторонами.
- ■ Курганы (круглые и квадратные).
- Херексуры.
- ⌚ Турецкие княжеские погребения.
- ▲ Каменные столбы.
- + Рисунки на скалах.
- ? означает, что тип памятника не совсем ясен.

10 20 30 км.

длина сетки = 10 км.

Словных знаков обозначают
типов сооружений в могильниках.

УДИРТГАЛ

1920-ИОД ОНЫ МОНГОЛ ОРОН БА МОНГОЛЧУУДЫН ЕРТӨНЦ

С.ЧУЛУУН, М.В.МЕДВЕДЕВА

1. Монгол дахь Г.И.Боровкагийн экспедици ба Монгол орон

Монгол орон дэлхийн эрдэмтдийн сонирхолыг татах болсон нь тэдний баялаг түүх, соёлын их өв сан хөмрөг, нүүдэлчдийн өвөрмөц соёл иргэншлийн онцлогтой холбоотой. XVII зууны эхнээс эхлэн Оросын элч нар, аажимдаа XVIII зууны эцэс үеэс Монгол орныг судлах сонирхол ихээхэн идэвхжсэн юм. Харин XX зууны эхэн болоход Монголчууд бие даасан улс байгуулж, өөрийн шинжлэх ухааны анхны байгууллага (Учком) үүсэж буй болов. Шинэ байгуулагдсан Шинжлэх Ухааны байгууллагаас гол хамтран ажиллаж байсан улс нь Зөвлөлт Холбоот Улс болно.

Зөвлөлт Холбоот улсаас олон тооны шинжилгээний ангиуд Монгол нутагт ирж хээрийн судалгаануудыг явуулах болов. Мэдээж үйл ажиллагааг зохицуулах гол байгууллага нь Зөвлөлтийн талаас "Монголын комисс" байлаа. Тэдгээр олон шинжлэх ухааны чиглэлийн шинжилгээний ангиудын дотор археологийн шинжилгээг явуулах нэгэн чухал анги байсан нь Г.И.Боровкагийн удирдсан Туул голын сав хөндийд явуулсан шинжилгээний анги байв.

1923 оноос Монголд ажиллаж эхэлсэн П.К.Козловын удирдсан Монгол-Түвэдийн экспедицийн үйл ажиллагааг улам өргөжүүлэх зорилгоор С.А.Теплоуховын хамт Г.И.Боровкаг Оросын Эдийн соёлын түүхийн хүрээлэнгээс томилов. Хамгийн гол нь түүнийг скифийн амьтны загварт урлагийн чиглэлээр судалгаа хийдэг учир Ноён уулаас олдсон амьтны загварт хивс зэрэг зүйлсийг судлуулахаар илгээсэн байна. Үнэн хэрэгтээ П.К.Козловын зүгээс Ноён уулын малтлагын байдал нэлээд хүндэрсэн учир Оросын Газарзүйн Нийгэмлэгийн нарийн бичгийн дарга В.Л.Комаровт захидал илгээнээс хойш хэсэг хугацаа өнгөрсөн дараа тэднийг илгээх шийдвэрийг гаргажээ. ШУА-ийн саналыг Зөвлөлтийн Засгийн газар амархан

дэмжсэн нь тэднийг илгээхэд санхүүгийн хүндрэл байхгүй байсантай холбоотой байжээ.

Г.И.Боровка үндсэндээ Монголд 1924, 1925, 1926 онуудад нийт 3 удаа ажилласан байна. Тэрээр анх удаа 1924 онд ирж Ноён уулын малтлагад оролцож судалгааны нэг хэсгийг удирдаж ажилласан бөгөөд амьтны дурслэл бүхий дурсгалуудыг Ленинград (одоогийн Санкт-Петербург) тусгай гэрээ хийж авч явсан байдаг. Анх удаа Монголд явахынхаа өмнө ээждээ бичсэн захидалдаа:

"Хайрт ээж минь өнгөрсөн долоон хоногт миний амьдралд өөрчлөлт гарлаа. Би 8 сараас экспедицээр Монгол улсыг зорихоор боллоо. Тэндээс чухал олдвор олсон гэнэ. Сонины тэмдэглэлээс үзвэл скифчүүдтэй холбоотой олдвор олдсон байна. Одоо тэдгээр олдворууд дээр эрдэм шинжэлгээний судалгаа хийх шаардлагатай болсон. Тиймээс би өөрийн хүсэлтээр явж оролцохоор боллоо. Дараагийн долоо хоногт миний явах шийдвэр гарвал бодох санах юмгүй шууд л явах болно. Энэ ажил миний хувьд маш чухал алдаж болохгүй боломж юм" гэжээ (Zerbst-Boroffka 2015).

Үнэхээр Г.И.Боровкагийн хувьд энэ удаагийн Монголд ажиллах зорилго нь сэтгэл хөдөлгөсөн, маш их яарч байсан экспедиц байлаа. Тэрээр 1924 оны 9 сарын 19-нд анх Монголд ирж Хараагийн Ноён ууланд 10 сарын 6-ны өдөр анхны малтлагаа эхэлжээ (Юсупова 2010). Малтлага судалгааны үр дүн ч маш гайхалтай байсныг П.К.Козловын олсон дурсгалуудаас мэдэх боломжтой.

Тэрээр анхны монголд Хүннүгийн булш малтсан тухайгаа ээждээ бичсэн захидалдаа их л сэтгэл хөдлөж бичсэн байдаг. Чухам ямар шалтгааны улмаас болсон юм энэ удаагийн малтлага намар өвлийн хүйтэнд өрнөсөн шинжтэй байна. Малтлага үндсэндээ 1 сар гаран үргэлжилсэн гэж Ю.И.Елихина тэмдэглэжээ (Елихина 2017). 10 сарын 7-нд хаягласан захидалдаа анх Сүжигтэд



ирлээ "удахгүй малтана" гэсэн бол 1925 оны 1 сарын дундуур бичсэн захидалдаа

"Уг орон гайхамшиг эртний түүхийн дурсгалаар дүүрэн аж. Долоо хоног бүр хүйтэн жавар, цасан шуургатай. Малтлага хэцүү нөхцөлтэй байсан хэдий ч бид булшийг бүрэн малтаж дуусав. Козлов болон бид нарын малтлагаас илрүүлсэн олдворуудаас МЭӨ болон манай эриний эхэн үед оршин тогтосон Төв Азийн олон соёл харилцаатай холбоотой асар сонирхолтой үр дүн гарав" (Zerbst-Boroffka 2015)

Гэж тэмдэглэснээс мэдэж болно. Үүний учрыг би эсвэл нэгэнт цаг хугацаа байхгүй тулгамдсан учир арга буюу өвлөөр малтсан эсвэл хөлдүү үед малтах нь булш нурах, шавар намаг болохоос хамгаалсан аль нь болохыг хэлэхэд бэрхшээлтэй юм. Г.И.Боровкагийн малтлагаас илэрсэн хамгийн чухал зүйл нь Грекийн үеийн хивс, даавуун эдлэл олдсонд машид их олзуурхаж түүнийг хэрхэн судлах тухай тэмдэглэсэн байдаг. Тэдгээр дурсгалын тухай С.А.Теплоухов 1924 оны 11 сарын 14-нд Судар бичгийн хүрээлэн дээр тайлан тавьж, 17-ны өдөр "Хуучны дурсгалт эд зүйлийг хамгаалах тухай" хуулийг үндэслэн тусгай гэрээ байгуулжээ. Эдгээр олдворуудын бараг ихэнхийг тэрээр Судар бичгийн хүрээлэнтэй тусгай гэрээ байгуулан 1925 оны намрын 9 сараас оройтуулалгүйгээр буцаж ирэх нөхцөлтэйгээр Эрмитажид авч явсан байна. Ленинградад очсон дараа С.А.Теплоухов, Г.И.Боровка нар Зөвлөлтийн ШУА-ийн Комиссын хурал дээр тайлан илтгэл тавьж, оросын эрдэмтдийн сонирхлыг илүүтэй татаж эхэлсэн байна. Гэвч С.А.Теплоухов зав мутай хэмээн 1925 онд дахин Монголд яваагүй бөгөөд харин Г.И.Боровка 1925 оны 8 сараас Монгол улсад дахин ажиллах урилга авсан байна. Энэ удаагийн урилгыг мэдээж Судар Бичгийн Хүрээлэнгээс өгсөн байх. Тэрээр Москвагаас гарч Сэлэнгэ, Троицкосавск, Алтан булгаар дамжин Монголд 1925 оны 7 сарын 31-нд Улаанбаатарт ирсэн байна. Шууд ирээд Ноён ууланд гарах гэсэн боловч борооны шалтгаанаас болж гарч чадсангүй.

Тэрээр 8 сарын дунд хүртэл Улаанбаатарт хэдэн өдөр saatnsны дараа Туулын сав нутаг дагуу археологийн хайгуул судалгаа хийхээр болжээ. Үүний учир нь бороо маш их байсан учир Ноён ууланд ажиллах явдал бүтэлгүйтсэн байна. Тийм учраас Судар бичгийн хүрээлэнгийн хүсэлтээр Туул голын хөндий дэх археологийн дурсгалуудыг судлахаар хөдөлсөн байна. Энэ тухайгаа өөрийн ээждээ 1925 оны 8 сарын 19-нд бичсэн захидалдаа:

"Нэг цагийн дараа бидний 2 сарын турш 400 км явах археологийн морин цуваа аялал эхэлнэ.

8 тэрэг, 10 хятад ажилчид, 1 монгол замын хөтөч, 1 орос орчуулагч, би болон Монголын Судар бичгийн хорооноос ажлын анд нөхрын хамт. Хар бараан үүлэн дундаас мандах нар цухуйж байгаа нь сайхан өдөр болох шинжтэй. Магадгүй сайн зүйл болохыг бэлгэдэж байгаа байх" хэмээн бичжээ (Zerbst-Boroffka 2015).

Монгол улсын Үндэсний Төв Архивын баримтын сангаас түүний Монголд ажилласантай холбоотой баримтуудыг шүүрдэж үзвэл

"Монгол Ард улсын Судар бичгийн хүрээлэнгээс Монгол Ард улсын Дотоод Явдлын яаманд хуудас өргөн илгээн явуулахын учир. Эдүгээ Манай Судар бичгийн Хүрээлэнгээс Орос эрдэмтэн Боровkad харьят хүрээлэнгээс дагалдан одох монгол Эрдэмбаяр, газарч Батболд, хөдөлмөрчин орос хүн нэг, хятад арав дагалдуулан хуучин эх түүхэнд холбогдох хөшөө чулуу ба булшны зэрэг зүйлийг шинжлэн олж малтаж үзэх зэрэг хэргээр Богд Хан уулын аймгийн Баян-Эрхт уул, Хутаг-Өндөр уул, Хүнцэлчлибид хан уулын хошууд ба Туул голыг уруудан уналаа морь 3, ачих тэрэгтэй морь 8, майхан, бие хамгаалах бичиг олгохыг гүйж дотоод яамнаа хуудас өргөн илгээв 15 оны 8 сарын 10" (МУУТА.ф.23, д.1, хн.66, х. 127-127а).

Гэсэн баримт бий. Түүний ээждээ бичсэн захидалтай Монголын архивын баримт хоёр бараг ижил байна. Мөн уг экспедицийн аюулгүй байдлыг хангах үүднээс Судар бичгийн хүрээлэнгээс Цэргийн яаманд хүсэлт гаргаж 1 буу, 100 сум олгож өгсөн ба тус шинжилгээний ангид ихээхэн анхаарал халамж тавьж байсан байдаг. Г.И.Боровкаг экспедициээр явах үед Судар бичгийн хүрээлэнгээс Монголын түүх, соёлын дурсгалыг хулгайгаар сүйтгэж байгаа хүмүүсийг олж илрүүлэх, барьж ирүүлэх, олсон олдворыг хураан авахыг мөн даалгажээ. Энэ тухай архивын баримтад:

"...Үнэмлэх тамга шийтгэн олгосон учир. Байцааваас манай Монгол улсын газар дотор буй бүхий хуучин дурсгал болох зүйл цөм Монгол улсын өөрийн хөрөнгө болох тул Судар бичгийн хүрээлэнгийн мэдэлд байх ба зөрчигч буй аваас шүүх цаазын зохих зүйлүн ёсоор яллан шийтгэвээс зохимой хэмээсэн зүйл буй бөгөөд үүнд Зөвлөлийн Засагт Холбоот улсын Академи наукаас урьж ирүүлсэн Орос эрдэмтэн Боровка нар манай хүрээлэнгээс Богд хан уулын аймгийн Баян-Эрхт уул, Хутаг-Өндөр уул, Хүнцэлчлибид хан уулын хошууд ба Туулын гол уруудан хуучин эх түүхэнд холбогдох

хөшөө чулуу ба булшны зэрэг зүйлийг шинжлэн олж малтаж үзэх зэрэг хэргээр томилон гаргасны тулд аливаа газарт энэ мэт зүйлийг зоргоор хулгайлан малтагчид тохиолдох болбоос харьят нутгийн эрх баригчдад хэлж шууд зогсоох ба малтаж олсон юм зүйлийг хураан авчирах эрхийг мөнхүү Борока нарт олгож гаргаж мэдэгдэхээс гадна зөрчин малтагчдыг уг дүрэм ёсоор дагаж шийтгэвээс зохимой” (МҮҮТА. ф.23, д.1, хн.66, х.131).

Хэмээн Г.И. Боровка нарт бас хууль бус малтлага хийсэн хүмүүсийг хянах үүрэг давхар өгч байжээ. Ийнхүү Г.И.Боровка нар 1925 оны 8 сарын 19-нд Өргөө буюу Улаанбаатар хотоос баруун өмнө зүг Туул голыг уруудан хөдөлсөн байна.

Улсын Архивт буй түүний Туулын сав уруудан явсан маршрутын тухай баримтаас үзвэл 1925 онд Улаанбаатар хот-аймгийн яам хүртэл (одоогийн Төв аймгийн Лүн сумын хавь) Туулыг уруудаж- Цэцэрлэгийн замаар Улаанбаатар хот оров” хэмээн тэмдэглэжээ (МҮҮТА. ф.23, д.1, хн.161, х.51а). Шинжилсэн зүйл нь замын гудасын хуучны балгасын байдал, зарим булш зэргээр нягтлан шинжлэж үзэв хэмээн тэмдэглэжээ. Г.И.Боровкагийн явсан байдлыг үзвэл Улаанбаатар хотоос гарч Туул голыг уруудан одоогийн Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Улахын буланг тойрч эртний Түрэгийн хаант улсын үеийн “Өнгөтийн дурсгал”-ыг судлан шинжилж эхэлсэн байна. Тэднийг хотоос гараад З хонож байхад Хэнтий, Туулын дээд эхэнд ажиллаж байсан Б.Я.Владимирцовын экспедиц Улаанбаатарт буцаж ирэн Г.И.Боровкагийн хойноос нэхэн ирсэн байна. Б.Барадины тайлан тэмдэглэлд

“наймдугаар сарын 23... Экспедиц Туулын хөндийн дагуу биднээс доош 10 бээрийн газарт байжээ. Бид энэ мэдээг сонсоод ихэд баярлаж экспедицийнхэний буудалласан газрыг зорив. Цагийн дараа бид нөхөр Боровкагийн экспедицийнхэн дээр очсон юм. ... хээтэй чулуун хавтангуудыг нь тэд төнхөн хугалжээ. Чулуун хавтангийн хээ Туулын эргийн Баян давааны аманд бидний харж байсантай бараг ижилхэн юм. Нөхөр Боровкагийн даалгаврын дагуу хятад ажилчид бага сага малтالت хийжээ. Наймдугаар сарын 24. Нөхөр Боровкатай салах ёс гүйцэтгээд бид буцах замдаа гарав”. (Номинханов 2016) (Фото. II 25148)

Б.Барадины тэмдэглэл, Г.И.Боровкагийн гэрэл зургийн огноо хоёр яг таарч байгаа юм. Энэ нь Г.И.Боровкагийн эдгээр гэрэл зургийн он цаг, өдөр маш нарийн бүртгэл

тэмдэглэгээтэйг илтгэнэ. Г.И. Боровка эртний түрэгийн булш, тахилгын газраас гадна хэд хэдэн газар дөрвөлжин булшийг малтан шинжилсэн байна. Түүнийг зарим судлаачид Монгол нутагт дөрвөлжин булшний судалгааг анх хийсэн судлаачдын нэг гэж үздэг юм.

Тэрээр Туул голын сав дагуух хадны зураг, дөрвөлжин булш, түрэгийн үеийн дурсгалуудыг малтан судлах шинжлэх үзэх ажлыг хийж 1925 оны 10 сарын эхээр Улаанбаатарт буцаж ирсэн байна. Тэд ойролцоогоор 2 сар орчим ажилласан байна (МҮҮТА. ф.23, д.1, хн.67, х.14). Улаанбаатарт буцаж ирсний дараа эсвэл гарахаас өмнө авсан бололтой тухайн үеийн Улаанбаатарын зарим түх соёлын дурсгалт газрын зургийг нэлээд нарийн авсан байна. Түүний өөрийнх нь тэмдэглэнсээр буцаж ирсний дараа модон чимэглэл, байшин савны зургийг нэлээд авсан тухайгаа тэмдэглэнсээс үзвэл зарим зураг нь зун хөдөө гарахаас өмнө, зарим нь буцаж ирсэн даруйд болох нь тодорхой байна. Тухайлбал, Судар бичгийн хүрээлэнгийн 2 давхар хуучны асарын зураг, Богдын ногоон ордны зураг зэргийг Г.И.Боровкагийн цуглуулгаас мэдэж болно. Г.И.Боровка 1925 оныхоо Туулын хөндийд ажилласан хээрийн судалгааны тайлангаа 1927 онд тусгай ном болгон хэвлүүлсэн (Боровка 1927).

Тэрээр энэ удаагийн Туулын хөндийд ажилласан хээрийн судалгааныхаа туршид нийт 92 булш бунхан тэмдэглэн бүртгэж, олон тооны дурсгалын гэрэл зураг болон гар зургийг үйлдэж, зарим нэгэн дурсгалд малтлага судалгааг явуулжээ (Боровка 1927). Монгол улсын архивт хадгалагдаж буй түүний малтсан дурсгалын тоог үзвэл нийт 230 орчим дурсгалыг бүртгэн тэмдэглэсэн байна. Уг шинжилгээний анги нь Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгээс тусгайлан явуулсан анхны хээрийн малтлага судалгаа гэж тэмдэглэж болох тухай Г.И.Боровка өөрөө тэмдэглэсэн байдаг. Дөрвөн газар жижиг малтлага үйлдсэн байна. Жаргалантын хөндийд, Тариатын хийдийн ойролцоо, Өнгөт, Улаан хужир хэмэх газруудад малтсан байна. Нийтдээ бол 400 км явж хайгуул судалгааг хийсэн байна. Г.И.Боровка өөрийн хээрийн судалгаа товч тайлан нэлээд гэрэл зургийн хамт Судар бичгийн хүрээлэнд хүлээлгэн өгч дурсгалуудыг судалгаа хийхээр Эрмитажд авч явсан (Елихина 2017) Тус тайлан хожим ШУА-ийн Түүхийн хүрээлэнд, 2002 оноос Археологийн хүрээлэнд шилжсэн боловч харамсалтай 2015 онд Археологийн хүрээлэн Түүхийн хүрээлэнд нийлж, Түүх, археологийн хүрээлэн болоход хэн нэгэн авч үгүй хийсэн бололтой эргэж ирсэнгүй. Тэрээр өөрийн тайлан зохиолынхоо төгсгөлд Монгол орон бол маш өвөрмөц бөгөөд бүх талаас нь өргөн хүрээнд судлах ёстой газар нутгийн нэг болно хэмээн тэмдэглэсэн байдаг.



Тэрээр Улаанбаатарт хэсэг суугаад 11 сарын 14-нд Дээд Үд орох машин олсон учир нэгэнтээ буцаж 12 сарын 2-нд Ленинград хотноо хүрчээ. Түүний 1925 оны Туулын хөндий дэх судалгааны ажил нь хэдийгээр богино хугацаанд боловч Түрэг, хүрэл зэвсгийн үеийн өвөрмөц дурсгалуудыг анх удаа малтан судалж, судалгааны эргэлтэд оруулах ажлыг гүйцэтгэсэн нь ихээхэн чухал экспедиц болсон гэж үзэж болно. Гэвч Г.И.Боровкагийн хамгийн гол сонирхол нь Ноён ууланд ганц болтугай булш малтах хүсэл хэвээр байв.

Тэрээр 1924 оны анхны судалгааны үр дүнд Эрмитажд авч явсан Ноён уулын дурсгалуудын нэлээд хэсгийг 1926 онд ирэхдээ авч ирсэн. Түүний хүсэл Ноён ууланд ажиллах хүсэл 1926 онд сая биелсэн юм. Г.И.Боровка Ноён уулын 49 булшийг бие даан малтсан. Түүний малтлагын тухай академич А.Е.Ферсманд илгээсэн цахилгаандаа "...малтлага цар хүрээгээр томгуй, үр дүн нь бага, гэхдээ сонирхолгүй бус" хэмээн бичжээ. Уг булш нь язгууртны болох нь тодорхой юм. Олдворуудын хувьд "...3 ширхэг духавч, морины тоног хэрэгсэл, суран бус, төмөр амгай, даавууны хэсэг, алхаж буй морин дурс бүхий 5 товруу, чий будагтай аяга, төмөр хадаас, төмөр саваа, нүүрсний дээж, алтан хуудсаар бүрсэн хадаастай дугуй товруу илрүүлсэн байна. Эдийн соёлын түүхийн улсын академиас 44 зүйлийн эд Улсын Эрмитажид 1938 онд ирсэн алтан товруу зэргийг 1937 онд шилжүүлжээ" (Елихина 2017) Түүний 1926 оны маршрутыг харвал дараах байдалтай байна. Улаанбаатар хот-Ноён уул-Мандал Тосгон- Улаанбаатар хот гэсэн байна.

Г.И.Боровка ийнхүү Монгол улсын нутагт 3 жил археологийн судалгаа хийж нэлээд тооны малтлага судалгаа хийсэн бөгөөд түүнийг судлах, судалгааны эргэлтэд оруулан хэвлэн нийтлэх, сэргээн засварлах зэрэг ажлуудыг нэлээд амжуулсан боловч дахин монголд ажиллаагүй юм. Тэрээр богино хугацаанд боловч Монголын археологийн судалгаанд нэлээд амжилт гаргаж чадсан төдийгүй хожмын судлаачдад хэрэг болохуйц ховор гэрэл зургийн сан хөмрөгийг үлдээж хоцроосон юм. Түүний гэрэл зургийн цуглуулга нь дан ганц археологийн судалгааны тухай бус тухайн үеийн монгол орон, монголчуудын нэгэн цаг үеийн түүхийг өгүүлж чадаж байгаагаараа онцлогтой.

2. Г.И.Боровкогийн гэрэл зургийн цуглуулгын тухай товчхон

Оросын Шинжлэх Ухааны Академийн Эдийн соёлын түүхийн хүрээлэн нь дэлхийд ховор баялаг баримтын

архивтай юм. Гэрэл зургийн материалын цуглуулга нь XIX зууны дунд үед гэрэл зураг анх үүссэнээс эдүгээг хүртэл гэрэл зургийн урлагийн бүхий л хөгжлийн үе шатыг бүрэн тусган харуулж чадна. Харин гэрэл зургийн цуглуулга нь тус хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний архивын гэрэл зургийн салбарт тусдаа хадгалагддаг. Тэдгээрээс түүхэн зургийн бүхий л төрөл зүйлийг үзэж болно. Цуглуулгын үндсэн цөм нь археологийн материалын боловч гэрэл зургийн сэдвүүд нь зөвхөн археологийн судалгаагаар хязгаарлагдсангүй юм. Манай архивт судалгаа шинжилгээний хатуу дэгээр авсан эрдэм шинжилгээний экспедицийн ажлын зургуудаас эхлээд Их Ван ноёдод зориулан үйлдсэн гоёмсог цомог, нууцлаг тальботип зургаас эхлээд XIX зууны хоёрдугаар хагасын энгийн хар цагаан гэрэл зургууд болон 1890-ээд оны 40x50 см хэмжээтэй гоёмсог шилэн негатив, нарийн хальсны өчүүхэн жижиг кадрууд зэрэг олон янз дүрслэл, жанртай янз бүрийн газар орон, он дараалал бүхий өөр өөр арга техникээр авсан гэрэл зургуудыг үзэж болно. Эдгээр гэрэл зургууд нь Оросын эээнт гүрний соёл түүхийн өвийн олон талыг харуулах бөгөөд Европ, Ази болон Африкийн улс орнуудын түүхэнд холбогдох фотоматериалууд ч бий.

Манай фотоархив (2004 оноос хойш Эрдэм шинжилгээний архивын гэрэл зургийн хэлтэс болсон) нь гэрэл зургийн тусгай хадгаламж болгон 1918 онд бий болсон боловч архивын цуглуулгын үүссэн нь түүнээс хамаагүй өмнө бөгөөд XIX зууны хоёрдугаар хагасаас XX зууны эхэн хүртэл Хаант Оросын археологийн судалгааны байгууллагуудыг тэргүүлэгч Оросын Эзэн хааны археологийн комиссын үйл ажиллагаатай холбогддог (Длужневская 2013). 1917 гэхэд тус комиссын архивт археологийн негатив болон гэрэл зургийн сэдвэчилсэн цуглуулгын төвлөрсөн архив буй болсон байсан юм.

XIX зууны хоёрдугаар хагасаас эхлэн газарзүй, угсаатан судлал, археологи, соёлын түүх, архитектур болон бусад салбарын судлаачид өөрсдийн судалгаанд гэрэл зургийг шинжлэх ухааны баримтжуулалын бодит арга хэмээн үзэж идэвхтэй хэрэглэх болсон билээ. Ялангуяа томоохон эрдэм шинжилгээний болон худалдааны экспедицийн үеэр гэрэл зураг авах нь тогтмол зүйл болж, экспедицийн удирдагчид гэрэл зургийн баримтжуулах аргын амар хялбар, түргэн шуурхай талыг тун ч удалгүй ойлгож дүрслэлийн болон жанрын тавилттай зургуудыг буулгаж гэрэл зурагчиддаа орон нутгийн байгалийн байдал, уран барилга, болон нутгийн хүн амын угсаатны зүйн мэдээллийг харуулсан зураг авах даалгавар өгөх болжээ. Оросын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний архивт 1874-1875 онд Хятадад явуулсан Оросын эрдэм шинжилгээ

худалдааны экспедицийн гишүүн А.Н.Э. Боярский болон Алс дорнодоос Эрхүү хүртэлх 1875-1876 оны аяллынхаа үеэр В.В. Ланин нарын авсан Монгол орны анхны гэрэл зургууд хадгалагдаж байна (Дружневская 2006).

Октябрьин хуьсгалын дараа үеэс гэрэл зураг авах нь аажмаар археологийн судалгааны ажлын нэгэн салшгүй хэсэг болов. Хээрийн ажлын улирал бүрийн үе шат, дурсгалын үе давхарга, ажлын болон ахуйн дүр байдал, олон тооны болон салангид олдворын зургууд нь архивын хөмрөт орж хадгалагдан дараагийн судалгааны ажилд бэлтгэгдэх болсон билээ. Архивыг үүсгэн байгуулснаас хойш Оросын археологийн олон байгууллага болон судлаачдын хувийн сан хөмрөгөөс үүсэлтэй асар их гэрэл зургийн материалын цуглуулга хуралдсан байна (Дружневская 2013а, 2014).

1920-иод оны хамгийн сонирхолтой гэрэл зургийн цуглуулгудын нэг нь Эрмитаж болон Эдийн соёлын түүхийн академийн ажилтан Г.И.Боровкагийн удирдсан Оросын ШУА-ийн Монголын экспедицийн археологийн судалгааны ажлыг тусган харуулсан байдаг. Тус экспедицийн үеэр үйлдсэн 300 гаруй гэрэл зургийн хальс болон шилэн негатив эх хувь болон тэдгээрээс цаасанд буулгасан гэрэл зургуудаар бүрдүүлсэн хэд хэдэн цомог (ФО НА ИИМК РАН: отп. О.1243—О.1248, нег. II 25137-25448) Оросын Эзэн хааны археологийн комиссын шууд залгамжлагч болон Эдийн соёлын түүхийн академийн гэрэл зургийн фондод хадгалагдаж буй. 1925—1926 оны хооронд Г.И.Боровкагийн удирдлаган дор Туул голын хөндий дэх хиргисүүр, хадны зураг, чулуун хөшөө зэрэг дурсгалуудыг судалж Сүжигт болон Мандал дахь эртний язгууртны булшны малтлагыг хийж гүйцэтгэжээ (Боровка 1927; Юсупова 2006, 75, 77). Оршуулгын газрын ерөнхий байдал, малталтын явц дахь булшны байдал, хадны зураг, хүн чулуу зэргийг судлаачид тухай бүрт нь нарийн нягт гэрэл зурагт буулгаж баримтуулж байв. Улаанбаатарын модон архитектурын дурсгал болон угсаатны судлалын ач холбогдолтой монголчуудын төрх байдал, дээл хувцас, малгай, орон гэр, ахуйн эд хэрэгсэл, лам нар, баяр наадам, морины уралдаан, бөх барилдаан, цэргийн жагсаал зэргийн сонирхолтой гэрэл зургууд байна. Хээрийн байр, тээвэр болон экспедицийн гишүүд, Монгол орноор аялан явах үеийн замын дагуух орон нутаг зэргээс гадна П.К.Козлов болон Н.К.Рерих нарын экспедицийнхийн гишүүд Монголын Судар бичгийн хүрээлэнд 1926 онд уулзсан уулзалтын зургууд мөн байна (ФО НА ИИМК РАН: отп. О.1246/18-20; Дружневская 2011, 126-127; Юсупова 2006, 84).

Аз болоход 1925-1926 оны хооронд Г.И.Боровкагийн хөтөлсөн хээрийн гэрэл зургийн өдрийн тэмдэглэл (РО

НА ИИМК РАН: ф. 2, оп. 1, 1925, д. 241) нь Оросын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн архивын цуглуулгын бүрэлдхүүнд гар бичмэлийн хөмрөт нандигнан хадгалагдсаар иржээ. Энэ тэмдэглэлийн үндсэн дээр гэрэл зургийн архивын ажилтан К.Назарова 1937 онд Оросын ШУА-ийн 1925-1926 онд явуулсан Монголын экспедицийн гэрэл зургийн цуглуулгын данс тэмдэглэлийг үйлдсэн байна (ФО НА ИИМК РАН: ф. 46, опись коллекции А1536). Гэвч уг дансанд өдрийн тэмдэглэлийг бүрэн ашиглаж оруулсангүй ажээ. 1925-1926 оны гэрэл зургийн өдрийн тэмдэглэлээ Г.И.Боровка өөрийн гараар энгийн дөрвөлжин шугамтай дэвтэрт харандаагаар бичиж үлдээжээ. Ажлын эхний жилд Г.И.Боровка тэмдэглэлээ дэлгэрэнгүй хөтөлж явсан бөгөөд хүснэгт үйлдэж зураг авсан сар өдөр болон кадрын дугаар, цаг агаарын байдал, байрлалыг бөглөн оруулж гэрэл зураг хэр чанартай гарсан зэргийг тэмдэглэж байв. Энэ тэмдэглэлийн ачаар цуглуулган дахь олон гэрэл зургийг авсан цаг хугацааг минут хүртэл нарийвчлалтайгаар тогтоож, авсан цаг хугацааных нь дарааллаар байрлуулах боломжтой болжээ. 1925 оны тэмдэглэлийнхээ хамгийн эхэнд Г.И.Боровка ашигласан гэрэл зургийн аппарат болон дурангийнхаа маркийг дурдажээ. Тэдгээр нь C. P. Goerz Berlin Dopp-Anastigmat Serie III DAGOR 150 mmf/6.8. өргөн форматын дурантай Идеал хэмээх аппарат болно. Тус дуран нь 1892 онд анх худалдаанд гарч 1924 оноос үйлдвэрлэхээ болысон бөгөөд 30 мм диаметр бүхий жижиг хэмжээтэй 180 гр жинтэй эд байжээ. Тус дурангийн оптик нь сайн чанартай том хэмжээний зураг болон хөрөг авах боломж олгодог тул гэрэл зурагчид болон судлаачдын дунд их нэртэй байсан юм.

1926 оны тэмдэглэл нь харамсалтай нь мэдээллээр тийм ч баялаг бус бөгөөд бараг жирийн жагсаалт гэмээр юм. Эндээс харин Оросын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн архивын гэрэл зургийн цуглуулганд багтаж чадаагүй сонирхолтой гэрэл зургуудын тухай мэдээллийг олж болно. Тэдгээр зургуудад нь экспедицийн гишүүд болон ахуйн элдэв байр байдал дүрслэгдсэн байжээ. Жишээ нь уг жагсаалтад Хиагтын орон нутгийг судлах музейн анхны захирал П.С.Михно ажил дээрээ, В.И.Лисовский нохойн гөлөгнүүдтэй, Вильскийнхэн Мандалд гэрийнхээ өмнө, Кузнецов болон Лопацины гэр булийнхэн Зуунмодонд, экспедицийн орос ажилчид, Улаанбаатар дахь гаалийн хороо, машинаас зугтааж буй чононууд гэхчлэн дурдагдсан гэрэл зургууд байжээ. Эдгээр зургийг эрдэм шинжилгээний үнэ цэнэгүй гэж үзсэн бололтой архивт хурааж оруулсангүй аж.

Гэрэл зургийн тайлбарт бид гэрэл зургийн данс болон гэрэл зургийн тэмдэглэлийн бүхий л мэдээллийг бүрэн багтаахыг хичээсэн бөгөөд 1925-1926 оны хооронд Г.И.Боровкагийн удирдлаган доор Монгол орныг археологийн хувьд судалсан ажлыг тусгасан үнэт ховор цуглуулгыг бүрэн танилцуулахыг хичээсэн болно.

Архивын эх сурвалж, ном бүтээл

Монгол Улсын Үндэсний Төв Архив. ф.23, д.1, хн.66, х.127-127 а

МУУТА.ф.23, д.1, хн.66, х.131

МУУТА.ф.23, д.1, хн.67, х.14

МУУТА.ф.23, д.1, хн.161, х.51а

Рукописный отдел Научного архива Института истории материальной культуры РАН, ф. 2, оп.1, 1925, д.241

Фотографический отдел Научного архива Института истории материальной культуры РАН, ф. 46, колл. А1536, альбомы О.1243—О.1248

Боровка 1927 — Боровка Г.И. Археологическое обследование среднего течения р. Толы // Северная Монголия. Т. II. Предварительные отчёты лингвистической и археологической экспедиций о работах, произведённых в 1925 году. Л., 1927. С. 43-88

Васильков, Сорокина 2003 — Васильков Я. В., Сорокина М. Ю. Люди и судьбы. Биобиблиографический словарь востоковедов — жертв политического террора в советский период (1917-1991). СПб: Петербургское Востоковедение, 2003. 496 с.

Владимирцов 2002 — Владимирцов Б.Я. Работы по истории и этнографии монгольских народов. М.: «Восточная литература» РАН, 2002. 555 с.

Длужневская 2006 — Длужневская Г.В. Китай и его соседи в фотографиях русских исследователей и путешественников (материалы фотоотдела Научного архива ИИМК РАН) // Санкт-Петербург - Китай. Три века контактов. СПб., 2006. С. 85-105

Длужневская 2011 — Длужневская Г.В. Археологические исследования в Центральной Азии и Сибири в 1859-1959 гг. (по документам Научного архива Института истории материальной культуры РАН). СПб.: ЭлекСис, 2011. 296 с.

Длужневская 2013а — Длужневская Г.В. Научный архив Института истории материальной культуры РАН: история архива и хранители «вечности» // Академическая археология наберегах Невы (от РАИМК до ИИМК РАН, 1919-2014 гг.). СПб, 2013. С. 292-318

Длужневская 2013в — Длужневская Г.В. Фонды фотоархива Института истории материальной культуры РАН (ныне — фото отдел Научного архива ИИМК РАН) // Восточный архив. № 2 (28). М., 2013. С. 79-89

Длужневская 2014 — Длужневская Г.В. Фонды фото архива Института истории материальной культуры РАН (Окончание) // Восточный архив № 1 (29). М., 2014. С. 84-96

Китова 2010 — Китова Л.Ю. Сергей Александрович Теплоухов // Российская археология, 2010, № 2. С. 166-173

Юсупова 2006 — Юсупова Т.И. Монгольская экспедиция Академии наук. История создания и деятельности. 1925—1953. СПб: «Нестор-История», 2006. 280 с.

Елихина 2017 — Елихина Ю.И. Эрмитаж дахь Ноён уулын Эрдэнэс. УБ., 2017. тал. 13

Номинханов 2016 — Номинханов Ц.-Д. 1924-1925 онд Баруун Монголд хийсэн судалгаа-II. Улаанбаатар. 2016. Эрхлэн хэвлүүлсэн НА. Сүхбаатар. тал. 174-175

Юсупова 2010 — Юсупова Т.И. Археологийн тохиолдлын ба зүй тогтолцой нээлтүүд: П.К.Козловын Монгол-Түвэдийн экспедиц, Ноён уулын малтлага. // Түүхийн судлал. Улаанбаатар., 2010. тал. 20-21

Zerbst-Boroffka 2015 — Zerbst-Boroffka Irene. Leben und Wirken des deutsch-russischen Forschers Gregor Boroffka (1894–1942) Briefe (1913–1935) an die Familie aus Russland nach Deutschland. Hamburg, 2015, 324 S.

ВВЕДЕНИЕ

МОНГОЛИЯ И МИР МОНГОЛОВ 1920-Х ГОДОВ

М.В.МЕДВЕДЕВА, С.ЧУЛУУН

1. Экспедиция Г.И. Боровки в Монголию

Богатая история, величественное культурное наследие и особая кочевническая цивилизация монголов давно стали объектом пристального внимания исследователей из разных стран. Первые русские послы прибыли в Монголию в XVII веке, с тех пор интерес к ее изучению постепенно возрастал, и к концу XVIII века Монголия с ее самобытной культурой и традициями становится объектом научных изысканий русских ученых и путешественников. После обретения в начале XX века государственной независимости в Монголии в 1921 г. впервые создается собственная научная организация - Ученый Комитет. С самого начала своей плодотворной деятельности Комитет тесно сотрудничал с научными учреждениями и исследователями советской России.

В рамках многочисленных экспедиций, организованных при содействии Советского Союза, в Монголии активно проводились полевые работы. Главным куратором этого процесса с российской стороны являлась "Монгольская комиссия". Одним из важнейших археологических исследований в 1920-е гг. стала экспедиция под руководством русского археолога Г.И.Боровки¹, базировавшаяся в долине реки Тола и являвшаяся частью масштабной комплексной Монгольской экспедиции Академии наук СССР (Юсупова 2006).

Г.И.Боровка и С.А.Теплоухов² были командированы Российской Академией истории материальной культуры с целью расширить состав и направления деятельности

¹ Боровка (Боровко) Григорий Иосифович (1894-1942) – археолог, исследователь культур скифо-сарматской эпохи, сотрудник Государственного Эрмитажа и Российской Академии истории материальной культуры. Подробнее о нем см. Васильков, Сорокина 2003. С. 73-74; Zerbst-Boroffka 2015

² Теплоухов Сергей Александрович (1888-1934) – археолог и этнограф, в то время работал в Российской Академии истории материальной культуры, Ленинградском Государственном Университете, Этнографическом отделе Русского музея. Подробнее о нем см. Васильков, Сорокина 2003. С. 372-373; Китова 2010.

Монголо-Тибетской экспедиции под руководством П.К.Козлова, работавшей в Монголии с 1923 г. Изначально Г.И.Боровку как прекрасного специалиста в области скифского искусства пригласили для изучения ковра из Ноин-Улы. Но на самом деле после письма П.К.Козлова научному секретарю Российского Географического Общества о финансовой трудности экспедиции, они были отправлены в Монголию только через некоторое время.

В общей сложности Г.И.Боровка побывал в Монголии три раза: в 1924, 1925 и 1926 гг. В первый раз он руководил одной из групп на раскопках Ноин-Улы, после чего по условиям особого договора с Ученым Комитетом отвез обнаруженные во время исследований предметы искусства звериного стиля в Ленинград (ныне Санкт-Петербург). Перед поездкой он написал своей матери:

"Дорогая мамочка, на прошлой неделе, в жизни моей произошло изменение. С августа месяца собираюсь в экспедицию, в Монголию. Там обнаружена важная находка. Из сообщений газет явствует, что найдены памятники, связанные со скифами. Надо начать их научное изучение. Поэтому, по собственному желанию буду участвовать в этом деле. Если, на следующей неделе будет решен вопрос о моей поездке, не думая сразу поеду. Для меня эта работа - большая возможность, которую нельзя упускать" (Zerbst-Boroffka 2015)

Действительно, для Г.И.Боровки это была долгожданная и очень желанная экспедиция. Он прибыл 19 сентября в Монголию и уже 6 октября 1924 года приступил к раскопкам в Ноин-Уле (Юсупова 2010). О том, каких чудесных результатов они добились, мы знаем из памятников, открытых П.К.Козловым.

О своих первых раскопках гуннского могильника в Монголии Г.И.Боровка писал с глубоким воодушевлением. Работы по неизвестным причинам начались в холодный период монгольской осени и зимы, когда уже наступили морозы, и продолжались около месяца, как отметила

Ю.И.Елихина (Елихина 2017). О начале исследований сообщается в письме, датированном 7 октября 1924 года: "Прибыл в Судзуктэ, скоро приступим к раскопкам", а в другом письме, написанном в середине января 1925 года, говорится, что:

"Страна изобилует уникальными памятниками древности. Неделя, одна за другой, была морозной с метелями. Несмотря на трудные условия, в которых шли раскопки, мы сумели раскопать могилы полностью. Из находок, обнаруженных Козловым и нами, извлечены огромного интереса результаты, связанные с культурными сношениями Центральной Азии в период до н.э. и начала нашей эры". (Zerbst-Boroffka 2015)

О причинах такого решения можно только догадываться - либо у исследователей не было времени на ожидание следующего сезона, либо они пытались таким образом избежать осенней грязи и оползней, приступая к раскопкам зимой, когда земля уже промерзла. Самыми важными находками экспедиции Г.И.Боровки в тот год стали ковер и ткани бактрийского периода. В своем дневнике он отмечал особое значение исследований такого типа «древностей». 14 ноября 1924 года С.А.Теплоухов сделал доклад об этих находках и погребениях на собрании Монгольского Учкома, а 17 ноября был составлен особый договор на основании Закона о защите предметов древности. Большинство находок из раскопок были вывезены в Ленинград с условием вернуть их в Монголию не позднее сентября следующего 1925 года. По возвращении из экспедиции С.А.Теплоухов и Г.И.Боровка выступили на собрании комиссии АН СССР с докладами о блестящих результатах работ, их сообщения вызвали огромный интерес у советских ученых. В следующем году С.А.Теплоухов, ссылаясь на занятость, отказался от участия в экспедиции, и больше не ездил в Монголию, а Г.И.Боровка вновь получил приглашение поработать в экспедиции и летом 1925 года отправился на место проведения исследований. Прибыв в Улан-Батор через Троицкосавск 31 июля 1925 года, он не смог выехать в Ноин-Улу из-за продолжающихся проливных дождей.

До середины августа Г.И.Боровка находился в Улан-Баторе, дожди так и не прекращались, погода помешала его планам продолжить раскопки Ноин-Улы. В итоге, по просьбе Монгольского Учкома он отправился исследовать археологические памятники долины реки Тола. Об этом он писал своей матери 19 августа 1925 года:

"Через час начнется наш двухмесячный поход на лошадях, который должен пройти 400 км. Едем

я и товарищ по работе из Монгольского Учкома, 10 китайцев-рабочих, монгол - проводник и один русский- переводчик с 8 повозками. Проглянувшее солнце из-за темных облаков обещает хороший день. Будто предвещает что-то хорошее". (Zerbst-Boroffka 2015)

В фондах Национального Архива Монголии имеются интересные документы, содержащие сведения о деятельности Г.И.Боровки во время экспедиции 1925 года. В частности, сохранилось «Прошение Ученого Комитета Монгольской Народной Республики в Министерство Внутренних Дел Монгольской Народной Республики», в котором сообщается:

"Так как ныне из нашего Ученого Комитета отправляются российский исследователь Боровка, с сопровождающими из нашего комитета, с монголом Эрдэмбаиром, проводником Батболдом, с рабочими - 1 русский и 10 китайцев, для обследования исторических памятников и погребений на территориях хошунов Байн-Эрхэт-Ула, Хутук-Ундур-Ула, Хунцэлчибит-Ула аймака Богд-Хан-Ула вниз по реке Тола верхом на 3 лошадях, с 8 выючными лошадьми в повозках с палатками, просим Вас предоставить сопровождающее удостоверение 10-го числа 8-го месяца 15-го года". (ЦНА Монголии, ф.23. д.1. хн.66. х. 127-127 а)

Тексты прошения и приведенного выше письма Г.И.Боровки домой почти идентичны. Кроме всего перечисленного, по просьбе Учкома, Военное Министерство предоставило экспедиции одно ружье со 100 патронами. Важно отметить, что руководство Учкома также наделило археологов правом производить арест грабителей историко-культурных памятников, если такие попадутся на пути следования экспедиции, и конфисковывать у них награбленное. Об этом сообщается в архивном документе:

"Сим удостоверением «закрепленным печатью» уведомляется: Все старинные памятники находящиеся внутри нашей страны являются имуществом Монгольского государства, следовательно, находятся под ведомством Ученого Комитета. Нарушители караются законом. Российский ученый Боровка, приглашенный из Академии Наук Советского Союза, отправляется из нашего Ученого Комитета для обследования исторических памятников и погребений на территориях хошунов Байн-Эрхэт-Ула, Хутук-Ундур-Ула, Хунцэлчибит-Ула аймака Богд-

Хан-Ула вниз по реке Тола. И Боровка и другие наделяются правом останавливать работу встреченных по пути воровских грабителей через уведомление местных руководителей, и найденные ими памятники конфисковать и привезти. Нарушители же должны понести наказание по закону" (ЦНА Монголии, ф.23. д.1. хн.66. х.131)

Таким образом, Г.И.Боровка и другие сотрудники получили возможность и должны были в процессе исследований исполнять обязанности по охране памятников Монголии, препятствуя незаконным раскопкам археологических объектов и расхищению древностей. 19-го августа 1925 года экспедиция выехала из Улан-Батора по направлению на юго-запад вниз по реке Тола.

По архивным документам маршрут экспедиции выглядит примерно так: г. Улан-Батор – Администрация аймака (ныне Лун сомон Тув аймак) – вниз по Толе – по дороге Цецерлик–Улан-Батор (ЦНА Монголии, ф. 23. д.1. хн.161. т.51 а). В процессе экспедиции, как писал Г.И.Боровка, он "исследовал состояние старых городищ и погребений по маршруту". Судя по маршруту, выехав из Улан-Батора вниз по реке Тола, он начал работу с обследования древнетюркского Унгутского памятника, находящегося на территории нынешнего сомона Алтанбулаг, Тув аймака. Через три дня после их отъезда из Улан-Батора работавшая на верховьях Толы в Хэнтэй экспедиция под руководством Б.Я.Владимирцова³ вернулась в город и сразу выехала вдогонку за отрядом Г.И.Боровки. В отчете Б.Барадина⁴ сообщается:

